



# ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 138

Мандалговь

## Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 2, 77 дугаар зүйлийн 3, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 2 дугаар зүйлийн 2.2.г дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээс ТОГТООХ НЬ:

1. Дундговь аймгийн Байгаль орчны газарт ашиглагдаж байсан балансын дүнгээр 19128,1 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 396926,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цогцолбороор нь Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн хөрөнгийг тайлан баланст нэгтгэхийг Байгаль орчны газрын дарга Н.Гантулгад даалгасугай.

3. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх хөрөнгийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ